

Манмин Мэдээ

№ 41 2013 оны 12 сарын 8

Бүх алдар магтаал талархал нь амьд оршигч Бурханд байх болтугай!



Ер бусын гайхамшигт солонго (Мүан Манмин Сүм 2011 оны 1-р сарын 27)



Мүан Амтат усны газар (Хаежэ-мёон, Мүан-гүн, Жеоннам аймаг)



И Жей Руг Тэргүүн пасторын удирдсан Ариун Сүнсний Нэгдсэн их цуглаан 1992 он



Сүмийн 30 жилийн ойн баярын урлагын тоглолт (2012 оны 10 сарын 7)



Манмин Залбирлын Өргөөний ахлагч хадагтай И Букнимийн удирдаж буй Даниел залбирлын цаг



Манмины Зуны цуглаанаар эдгэрсэн хүмүүсийн гэрчлэл (2013оны 8-р сарын 5)



Бурхандаа алдрыг өргөн бүх дэлхийн ард түмэнд гэрэл цацуулах Канаан Сүм

- Энэ онд 31 жилийнхээ ойн баярыг тэмдэглэж байгаа Манмин Төв Сүм нь дэлхий даяарх 10,000 гаруй салбар сүм болон хамтран ажиллах сүмүүдтэй хамтран үй олон хүмүүсийг авралын зам руу замчилсаар байгаа билээ.

- Манмин Төв Сүмийн тэргүүн пастор И Жей руг пастор нь эцсийн үеийн авралын зорилгыг гүйцэлдүүлэхийн тулд тэмдэг гайхамшигуудыг үйлдээд зогсохгүй харин Есүсийн үйлдэж байсан шиг дахин бүтээх эрх мэдэлт хүчний нөлөөгөөр агуу ажлуудыг хийсээр ирсэн билээ.

- Манмины итгэгчид өдөр бүр нэг сэтгэлээр сүм чуулгандаа цугларцгаан, гал халуун залбирлаар үзэсгэлэнтэй сайхан сүнслэг сэтгэлээр өөрчлөгдөж, тэнгэрийн орны Шинэ Иерусалимд орох итгэл найдвараар дүүрэн болж байна.

- Мөн тусламжын үйл ажиллагаа болон сайн мэдээ ба авралын үйлсэд идэвхийлэн зүтгэж байна



Манмины хүндэтгэлийн цуглаанд дэлхийн 170 гаруй орны хүмүүс Жи Си Эн TV, Internet-р оролцож байна (Манай төв цуглааны төв танхим)



GCN TV (Жи Си Эн) телевизийн шууд дамжуулах New York-ийн Empire State Төв



Мексикт болсон WCDN-н 10 дахь удаагийн Христэд итгэгч Эмч нарын Олон Улсын чуулга уулзалт (2013 оны 6-р сар)



И Жей Руг Тэргүүн пасторын 57 хэлээр хэвлэгдсэн номнууд



Латин орнуудын Манмин Олон Улсын библейн сургуулийн 9дэх удаагийн лекц (2007оны 11-р сар)



Перугийн Ерөнхийлөгч Алезандро Толедотой Ерөнхийлөгчийн ордонд хийсэн уулзалт (2004 оны 11-р сарын 30)



И Жей Руг Тэргүүн Пасторын 2009 онд Израйльд хийсэн Нэгдсэн Их Цуглаан (2009 оны 9-р сарын 6-7)

Төрөлхийн зан чанараа бид өөрчилж чадах уу?

Олон хүмүүс би төрөлхийн нэг ийм зангаа хичнээн хичээсэн ч засч чадахгүй байна гэлцдэг. Хүн бүрт өөрийн гэсэн өөр өөр зан чанар байдаг болохоор ийм ийм зан нь хамгийн сайн гэж хэлж чадахгүй.

Гэвч зарим хүмүүсийн ааш зан бусдаас ондоо, бүр санаатайгаар бусадтай эв нэгдэл хагалж, харьцахад ч хэцүү байдаг. Тэр ч байтугай итгэгч хүмүүсийн дунд ч бусадтай харьцаж чаддаггүй, зан аашны хувьд доголдолтой хүмүүс ч байдаг учраас тэдний харилцаанаас болж уур амьсгал хэцүү болох үе олон тохиолддог.

Тухайлбал нэг нь их түргэн зантай, бүхнийг хурдан хийх гэдэг хүн нөгөө нь юмыг их удаан, ул суурьтай хашир хянамгай хийх гэдэг хоёр хүн байж гэж бодъё. Тэгвэл тэд ямар нэг ажил хийхдээ нэг нэгнийгээ дагаад хийнэ гэвэл үргэлж зөрчилдөж, байнга хэрүүлтэй байх болно. Мөн их бүрэг ичимхий, дотогшоо хүн эсвэл сөрөг бодолтой хүмүүс бусдад төвөг удаж, хоорондоо харьцаж чадахгүй байж ч болно. Тиймээс тэд өөрсдийнхөө зан чанарыг хаяж чадахгүй зууралдсаар л байх юм бол энэ нь хэвшил зан болно.

Тэгвэл бид яаж өөрсдийнхөө энэ муу хэвшил болсон зан чанараа хаях вэ? Бидийг гал халуун залбирч, бодож бясалгаж байх үед Ариун Сүнс бидэнд ямар төрлийн муу хэвшил болсон зан байгааг ухааруулж, илчилж өгдөг. Өөрийн бодол санаа зан аашаа хаяж, зөвхөн үнэнийг үйлдэж дагасанаар бид сүнслэг зүрх сэтгэлийг олж аваад зогсохгүй Бурхан Аавын сайхан сэтгэлтэй болж чадна.

Төрөл бүрийн зан авирын дундаас одоо гурван төрлийн хэвшсэн муу зан чанарыг судалцгаа!

Өөдрөг бус бодлоо үгүй хийхийн тулд



бүх зүйлд талархаж, Бурханы хайрыг мэдэрч, үргэлж баяртай байх хэрэгтэй

Гутранги үзэл танд байвал хүмүүстэй ярилцахдаа хүртэл өөдрөг сайхан үг яриа ярьж, итгэлийн гэрчлэл хийхийн оронд өөрөө ч мэдэхгүй зовлон гуниг, бүтэлгүйтлээ тоочинбусдад эвгүй сэтгэгдэл төрүүлэх нь олонтаа байдаг. Энэ нь бусдад ч тус дэм ивээл болж чаддаггүй. Мөн бусдыг гомдоох юмуу ямар нэгэн буруу зүйл хийвэл бусдаас уучлал гуйж харьцаагаа сэргээж сайн болгоё гэж хичээдэггүй харин нөхцөл байдлаас зугтаж, юу ч хийдэггүй байна.

Тэд ингэж зан аашны хувьд санаагаар унах, зан чанарын доголдлоосоо болж сэтгэл нь түгшүүртэй болдог учраас Бурханы хайр, жинхэнэ үнэнтэй нүүр тулж чаддаггүй. Гэвч Бурханд боломжгүй зүйл гэж байдаггүй болохоор хэрэв бид Бурхан дотор үнэнийг үйлдвэл боломжгүй зүйл нь боломжтой болж, болох зүйл нь бүр илүү сайн болдог байна.

Хэрэв бид чин сэтгэлээсээ итгэж, Бурханыг хайрлавал бид бүх зүйлдээ Түүнд талархаж, Бурханы хайрыг мэдэрч, цаг үргэлж баяртай байх хэрэгтэй. Гэвч гутранги бодолтой хүмүүс баяртай байна, талархаж байна гэж хэлсэн ч зүрх сэтгэлд нь санаа зоволт байсаар л байдаг. Хэрэв тэдэнд ямар нэгэн таагүй, хэцүү асуудал тулгарвал итгэлээрээ даван туулахыг хичээсэн ч тэд “Буруудвал яах вэ?” гэсэн бодол байдаг. Бүр сайн сайхан зүйл тохиолдсон ч “Хэрвээ энэ буруугаар эргэчихвэл яанаа?” гэсэн сөрөг бодол эргэлдэж сэтгэл зүрхэнд нь ирсэн баяр хөөр, талархал нь юу ч үгүй замхран алга болдог.

Тиймээс Бурханы хайрыг мэдрэхийг хичээж, бүхий л зүйлд талархаж, Бурханд залбирч итгэлээрээ явах хэрэгтэй. Ингэж чадвал тэдний зүрх сэтгэл болон оюун бодол нь эерэгээр өөрчлөгдөн шинэчлэгдэх болно (Филипой 4:6-7).

Дотуур зан чанарыг хаяхын тулд



бусдыг хайрлаж, халамжтай уужим сэтгэл ивэрлэн бодох хэрэгтэй

Дотуур зан чанартай хүмүүс өөрсдийгөө тийм ч амархан илэрхийлж чаддаггүй. Энэ нь төрөлхийн байж болно мөн бусдаас авсан шарх ч байж болно. Жишээ нь, хэн нэг нь тэднийг маш хүнд цохилтонд оруулж, эмзэг асуудлыг нь илчлэх юм уу эсвэл өөрийн дутагдалтай талаа илчлэх дургүй бусдаас аль болох нууцалсанаар өөрийгөө хөгжүүлж чадахгүй дотогшоо бүрэг зантай болдог байна.

Иймэрхүү дотуур зан чанартай хүмүүс маань тэр бүр бусадтай эвгүй харьцаад байдаггүй, эелдэг, эв нэгдэлтэй байдаг ч амар тайван мэдрэмж байдаггүй. Тэр ч байтугай тэд ямар нэгэн хорон муу зүйл хийхгүй ч бусдад сайн санаж, сайхан сэтгэлээр харамгүй ханддаг ч энэ нь үйлдэл нь бусдад төдийлөн

сайхан сэтгэгдэл төрүүлж чаддаггүй байна. Заримдаа иймэрхүү зан нь бусдад эвгүй сэтгэгдэл төрүүлж, гомдоодогтой адил сүнсний өсөлтөнд ч маш муугаар нөлөөлдөг. Бусдын зовлон, сэтгэл санааг ойлгохдоо тааруухан, бусадтай чин сэтгэлээсээ харьцаж чаддаггүй хүмүүс мөн л бусадтай сэтгэл санаагаа худаалцдаггүй, бусдын санаа сэтгэл ямар байгааг ч сонирхдоггүй байна.

Тэгвэл яаж зуршил болж хэвшсэн энэ зан чанараа засаж өөрчлөх вэ, яаж сүнслэг болох вэ? Бусдын зүрх сэтгэл, нөхцөл байдлыг бодолцож, анхаарал халамж тавьсанаар энэ зан чанараа хугалж хаях хэрэгтэй. Өрөөл бусдыг зүрх сэтгэлдээ хайраар, энэрэнгүй өрөвч, өргөн уудам сэтгэлээр өвөрлөн бодох ёстой. Ингэж л Бурханы хүссэн сүнслэг хүмүүс болж чадна.

Өөрийгөө дорд үзэх зан чанараа үгүй хийхийн тулд



бүхнийг дуулгавартай зүрх сэтгэлээр хамгийн сайнаар хийх хэрэгтэй

Бид ямарваа зүйлийг даруу зангаар хийсэн ч тухайн нөхцөл байдлыг хараад үнэн зөв, болно болохгүйг ялгаж чаддаг байх хэрэгтэй. Бид зарим нэг зүйлийг хийхдээ сайн хийж чаддаггүй гэж бодох ч ёсгүй харин эр зоригтойгоор Бурханы хайр, Түүний тусламжтайгаар бүр ч илүү сайн хийж чадна гэсэн итгэлтэй байх хэрэгтэй. Яагаад гэвэл бид Бурханы хаанчлалын төлөө хийх ёстой зүйлээ үнэнч шударгаар зоригтой хийж, урагшаа давшиж байх хэрэгтэй байдаг.

Өөрийгөө дорд үздэг зантай хүмүүс үргэлж юмнаас ухарч “надад ийм зан чанар, чадвар байхгүй, би ийм үүрэг хариуцлага хүлээж, хийж чадах хүн биш” гэж хэлдэг. Тэд хариуцлага хүлээхээс зайлсхийж “надаас хамаагүй илүү, сайн хийж чадах хүн хийсэн нь дээр” гэж хэлдэг. Зарим хүмүүс төрөлхийн өөрийгөө дорд үздэг зантай байлаа ч энэ зан чанараа ялан дийлж сайнаар хөгжүүлж чадсан байдаг. Гэвч олон жилийн турш амсаж өнгөрүүлсэн туршлагаас харахад тэд урьдын адил зориг зүрх нь байхгүй болж хальшрамтгай, аймтгай болдог.

Зарим хүмүүс өөрсдийгөө итгэлийн хадан суурин дээр суурилагүй, сүнс рүү ороогүй, болохоор Бурханы ажлыг итгэмжтэй сайн хийж чадахгүй гэж бодоод өөрсдийгөө хязгаарлан шугам татаж нэмждэг байна. Тэд нар ердөө л хойшоо ухарч зайлсхийх гэж оролддог. Тэдний хувьд итгэлээр өсөхийн тулд Бурханы хүчээр илүү эрч хүчтэй, үнэнч шударгаар ажиллахыг гуйх ёстой. Бид сүнс рүү орж, итгэлийн хадан сууринд суурилж чадаагүй байсан ч бүхнийг дуулгавартайгаар хичээнгүйлэн чадлынхаа хирээр хийж байгааг хараад хайрын Бурхан Аав маань бидэнтэй хамт ажиллах болно.

Дэд хууль 6:5-г уншвал “Чи өөрийн Бурхан ЭЗЭНийг бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч чадлаараа хайрла.” гэсэн байдаг. Хэрэв та Бурханы алдрын төлөө хайрын сэтгэлээр өгөгдсөн үүрэг даалгавараа хийж гүйцэтгэхийг хичээвэл таны зан чанар өөрчлөгдөж бүр ч илүү сайн давуулах хийх чадвартай болж гайхалтай сайн ажиллах болно. Ийнхүү та нэг, хоёр удаа хичээн зүтгэвэл Бурханы өгсөн эр зориг хүч чадлаар үүрэг даалгавараа илүү сайн хийж гүйцэтгэх болно.

“ЭНЭТХЭГ ХҮМҮҮСИЙН ТӨЛӨӨ ГЭСЭН БУРХАНЫ ХАЙР ДУУСАШГҮЙ”

Сэллиа Эбэнэзер ахлагч (Үйлдвэрийн ажилчдын нийгэмлэгийн залбирлын удирдагч, Энэтхэг, Чэннай хот)



Би Энэтхэгийн Тамил Наду мужын Мадурай хотын бол чинээлэг гэрт төрж, өсөж бойжсон бөгөөд спортод дуртай ба тамирчин болохыг мөрөөддөг байлаа. Гэтэл эцэг эхийн сайн сургамж болон амьдаарлын үзэл баримтлал нь намайг Эзэн рүү хөтлөн дагуулсан юм.

Би хавхлаг үйлдвэрлэх маш том компани үйлдвэрийн ажилчдын нийгэмлэгийн залбирлын удирдагчаар үйлчилдэг байлаа. Орон нутгийн пасторууд, сайн мэдээ тунхаглагчид санхүүгээр дэмжиж, номлогчдын тусламжтайгаар Чэннайд олон улсын Нэгдсэн Их Цуглааныг зохион байгуулсан билээ.

2002 онд Бурханы жинхэнэ дагалдагч И Жей Руг тэргүүн пасторын Энэтхэгт хийсэн Нэгдсэн их цуглаанаар дамжуулан эрх мэдэлт хүчийг мэдэрс

2002 оны нэг өдөр би нэгэн танил пастор Овен Робертоос И Жей Руг пасторын Нэгдсэн их цуглаан болох гэж байгаа талаар сонссон юм. Тэр үед би тухайн Нэгдсэн их цуглаан Зар суртчилгааны хорооны даргаар ажиллаж байсан болохоор олон төрлийн сонин, Телевиз, хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр дамжуулан зарыг тарааж байлаа.

И Жей Руг Тэргүүн пасторын 2002 онд хийсэн Нэгдсэн их цуглаан 3 сая гаруй хүн оролцож Энэтхэгийн Христидын дунд түүх болон үлдэж Бурханыг гайхамшигтайгаар алдаршуулсан билээ. Хэдийгээр олон хэцүү асуудлууд байсан ч энэ бүгд Бурханы ивээл ерөөлийг авах бэлтгэл байсан юм.

Ялангуяа, яг цуглаан эхлэхийн өмнө Тамил Наду-гаас эсэргүүцэж хүч хэрэглэн буу зэвсэг ашиглан тараахыг оролдож байлаа. Энэ нь зөвхөн цуглаан хийхээр бэлтгэж байсан пасторуудыг ч биш олон христийн хүмүүсийн итгэлийг шалгасан сорилт байсан юм. Буулт хийхээс өөр ямар ч сонголгүй байсан ч И

Жей Руг тэргүүн пастор зөвхөн итгэлээрээ энэхүү цуглааныг хийсэн юм.

Үр дүн нь төсөөлөхийн ч арагагүй байсан. Бурханы гайхамшигтай эрх мэдэлт хүч, тэмдэгт гайхамшигууд усны урсгал шиг гарч, үй олон хүмүүс Эзэнийг хүлээн авч, И Жей Руг тэргүүн пасторын сургаал болон залбирлаар олон хүн эдгэрч байлаа. Цуглаан тэр чигээрээ Бурханы мутарт Түүний тусламжтайгаар явагдаж байхыг би өөрийн нүдээр харсан. Бурханд бүх алдар магтаал, талархалыг өгч байлаа.

Эрх мэдэлт хүч болон ариун зарыг тараахын тулд Энэтхэгт Манмины Үйлчлэл бий болов

Энэхүү цуглааны дараа надад баг итгэл ирж, ариун зар сайн мэдээг тараах хүсэл маш их төрсөн. Тэгээд эцэст нь Энэтхэгт Чэннай Манмин Сүмд Хан Жон хи пастортай хамт Манмины үйлчлэлийг үүсгэн байгуулсанаас хойш ариун зар мэдээг тарааж, Бурханы хүчээр Үйлдвэрийн Ажилчдын Залбирлын багыг бий болгон, Пасторуудын семинарыг удирдан явуулдаг болсон.

Би Манмин Төв Сүмд хоёр удаа очиж маш их ивээл авсан. Гэртээ буцаж ирээд сүмийн талаарх бүх мэдээлэлийг дамжуулж, И Жей Руг тэргүүн пасторын сүнсэлг сургаалууд болон номнуудыг гэр бүл ах дүү, хамаатан садангууддаа бүгдэнд нь тараан өгч билээ. Үүний үр дүнд миний пастор зээ дүү нар Манмин Төв Сүмд очих маш их хүсэн тэмүүлэлтэйгээр зочлоод ирсэн билээ.

2013 оны Манмины Зуны Цуглаанд И Жей Руг Тэргүүн Пасторын хүчийг дахин харж гайхан биширсэн нь

2013 оны 8-р сард би Манмины Зуны Цуглаанд оролцож Бурханы агуу гайхамшигт хүчийг харсан билээ. 8-р сарын 5ны оройн 5.30д семинар эхэлсэн. Манмины урлагын тоглолтын дараа хөтлөгч сургаал заагчыг урихад бороо хэдэн дулаар орж байснаа бүр ширүүн орж эхэлсэн. И Жей Руг тэргүүн пастор ч, итгэгчид ч хичнээн бороо орж байлаа ч хөдөлгөөнгүй сууж байв.

Яг энэ үед 2002 онд Энэтхэгт хийсэн Нэгдсэн их цуглааны Здах өдөр И Жей Руг тэргүүн пастор маш хүчтэй ширүүн бороо орж байхад номлож байсан нь санагдаж үгээр илэрхийлэхийн аргагүй сэтгэл хөдлөлд автаж билээ. Энэтхэгт тэр үед 10 сарын турш бороо ороогүй тулд хүмүүс ундны ус ч үгүй зовж байсан үе. Тиймээс цуглаанд оролцож байсан хүмүүс сургаалыг маш баяр хөөртэйгээр сонсож байсан. Сургаал заасныхаа дараа тэр өвчин эдгээх залбиралыг тайзан дээрээс хийж өгөхөд маш олон хүн эдгэрсэнэ гэрчилж байсан. Энэ үйл явдлыг олон хүн зурагтаар харж, дараагийн өдөр нь тоо томшгүй олон хүн ирж цуглаанд оролцож байсан юм.

Энэ бүхэн бүгд надад санагдаж “одоо ямар ивээл ерөөлийг авах бол, Бурхан юу бэлдсэн бол?” гэсэн итгэл найдвар, горьдлого төрж байлаа. Хөтлөгч танилцуусаны дараа Тэргүүн Пастор эр зоригтойгоор “Бороо зогс. Борооны үүл замхарн алга бол! Од

харагдаж, тэнгэр цэлмэг бол!” гэж залбираад сургаалаа эхэлсэн юм.

Тун удалгүй гайхамшиг болж, бөөн хар үүлнүүд замрхан таран алга болж, бороо зогсож, тэнгэр цэнхэртэж цэлмээд, одод харагдаж байлаа. Бурхан бидэнд зөөлөн сэрүүн салхийг илгээж норсон хувцасыг хагааж байсан юм. Халлелүяа! Сургаалын дараа тэр өвчин эдгээх залбиралыг бүх оролцогчидод хийж өгөхөд төрөл бүрийн өвчтэй олон хүн эдгэрч гэрчлэл хийсэн билээ. Миний зээ дүү нар ч мөн эдгэрч би ч гайхалтай ивээл ерөөлийг авч байлаа.

Залбирлаар 22 жилийн турш өвчтэй байсан Виктор Селван пастор эдгэрч, 4 жилийн турш даралт ихдэх өвчнөөр шаналж байсан Симон пастор эдгэрлээ

Виктор Робинсон Селван пастор (Зион Гардеи Ассембл Бурханы Сүм) И Жей Руг тэргүүн пасторын Үхлийн өмнөх мөнх амийг амссан нь гэдэг номыг уншиж байхдаа маш их ивээл авч өдөр бүр GCN TV-г үздэг байжээ. 22 жилийн турш уургын илүүдэл болж шээсний хүчил хуримтлагдсанаас, өвдөгний үе нь хавдаж маш их өвддөг байсан. Мах идвэл их уураг ялгарч хөл нь бүр их хавдах учраас хоолны нарийн дэглэм сахиж ногоо иддэг байжээ.

И Жей Руг тэргүүн пасторын залбирлыг итгэлээрээ авахад түүний өвчин байхгүй болж эв эрүүл болсон байна. Тэр одоо шатаар дээш доош ямар ч өвчин зовиургүй чөлөөтэй явж, ямар ч асуудалгүйгээр мах иддэг болжээ. Пастор Сатя Мүүти Паул дөрвөн жилийн турш цусны даралт ихдэх өвчтэй байсан бөгөөд залбирлаар эдгэрч Манмины үйлчлэлд илүү их итгэмжтэй болж Бурханд талархал өргөж байна.

Би их олон гадаад пасторуудтай уулзаж байсан ч И Жей Руг пасторыг хамгаас илүү хайрлан хүндэтгэж явдаг. Энэтхэгт одоо хүртэл олон пасторууд, итгэгчид И Жей Руг Пасторыг дурсан санаж, түүний энд хийсэн цуглааны тухай ярьдаг. Бүхий л алдар, магтаал, талархалыг жинхэнэ хоньчинтой уулзуулж өгсөн, энэтхэгийн 1.2 гаруй тэрбум хүнийг хайрладаг, бүх хүмүүсийг аврагдаасай гэж хүсэн тэмүүлж байгаа Бурхандаа өргөж байан.



Муан Амтат Усны Хүч чадал... Элдер Эбэнэзер зээ дүү нарынхаа хамт: (зүүнээс баруун тийш – Пастор Симон, Пастор Даниел Аллен Робинсон түүний эхнэр нь, Элдер Эбэнэзер, Пастор Виктор Селван)

Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:

Г. Анхбаяр СМТ 976-91173712
976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,
152-848 Солонгос Улс

Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048

http://www.manmin.org/english

www.manminnews.com

e-mail: manminministry@manmin.org

Нийтлүүлэгч: Жаерок Лее

Редактор: Геумсун Вин